



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

XVIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XVIII хурал 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 12:00 цагаас Төрийн ордны “Нээлттэй сонсголын танхим”-д 92 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтувшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Замын-Үүд боомтын улс хоорондын ачаа тээвэрлэлтийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

Зам, тээвэр хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Энх-Амгалан

2. Тулгар төрийн 2229, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулах талаар;

Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын
дэд сайд Г.Ганбаяр

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

А. Олон улсын нислэгийг түр зогсоосонтой холбогдуулан эх орондоо ирэх хүсэлт гаргасан, хүндэтгэн үзэх шалтгаантай Монгол Улсын иргэдийг Улаанбаатар – Сөүл – Улаанбаатар, Улаанбаатар – Франкфурт – Улаанбаатар чиглэлийн захиалгат нислэгээр татан авчрах ажлыг зохион байгуулах;

Б. Үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулан Замын-Үүд боомтоор онцгой нөхцөлд экспорт, импортын ачаа тээвэрлэлтийг зохицуулах түр журам боловсруулж Улсын онцгой комиссын даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахаар тус тус шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан,
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Г.Ганбаяр нарт:

1.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын нээлт, Төрийн хүндэтгэлийн концертын бэлтгэл сургуулилтыг Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас гаргаж буй тусгай горим, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэх ажлыг 2020 оны 5 дугаар сарын 01-нээс эхлүүлэх;

1.2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаа сунгагдан Үндэсний их баяр наадмыг нийтээр тэмдэглэх боломжгүй болох тохиолдолд наадмын нээлт, Төрийн хүндэтгэлийн концертыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах эсэх талаар саналаа Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороогоор хэлэлцүүлэн Улсын онцгой комиссоор шийдвэрлүүлэх;

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү
Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдарыг чийрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаас тавих шаардлагуудыг бүрэн хангасан, тусгай горимоор ажиллах үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг үе шаттайгаар нээх, хяналт тавьж ажиллахаар тус тус тогтов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

УХА0168

Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙНДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН